

МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Зорилго

Энэхүү Мэдээлэл хүргэх үйл ажиллагааны журам (“**Журам**”)-ын зорилго нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“**Компани**”)-иас эрх бүхий байгууллагуудад болон хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, Компанийн мэдээллийг нийтэд мэдээлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хамрах хүрээ

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (“**ТУЗ**”)-ийн гишүүд, түүний нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан болон Компанийн дотоод мэдээлэл эзэмшигч энэхүү Журмыг дагаж мөрдөнө.

Энэхүү Журмыг аливаа сонирхогч этгээдийн хүсэлтээр танилцуулж болох ба Компанийн цахим хуудаст байршуулна.

1.3. Хяналт, нэмэлт өөрчлөлт

Энэхүү Журмыг Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга 3 жил тутамд хянаж шаардлагатай бол түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг батлуулахаар ТУЗ-д танилцуулах ба аливаа өөрчлөлтийг ТУЗ баталснаар хүчин төгөлдөр мөрдөнө.

1.4. Журмын нөхцөл

Энэхүү Журам болон Компанийн Дүрэм (“**Дүрэм**”)-ийн хооронд зөрүү үүссэн тохиолдолд Дүрэм давуу хүчинтэй байх ба энэ Журам нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцээгүй тохиолдолд сүүлд батлагдсан хуулийн зүйл, хэсэг, заалт давуу хүчинтэй байна. Энэхүү Журмын заалтууд хэрхэн тайлбарлах талаар тодорхойгүй байдал, санал зөрөлдөөн үүссэн, Журамд тусгагдаагүй аливаа асуудал гарсан тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын журам, зааврыг дагаж мөрдөнө.

1.5. Нэр томьёо

Энэхүү Журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

- 1.5.1. **Дотоод мэдээлэл** гэж Компанийн үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх нийтийн хүртээл болоогүй мэдээллийг хэлнэ.
- 1.5.2. **Дотоод мэдээлэл эзэмшигч** гэж Компанийн Дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчдийн үйл ажиллагааны журмын 1.5.2-т заасан этгээдийг ойлгоно.
- 1.5.3. **Нийтийн хүртээл болгох** гэж Компани нь холбогдох хууль тогтоомж болон энэ Журамд заасан дотоод мэдээллийг Компанийн болон Монголын хөрөнгийн бирж (“**МХБ**”)-ийн цахим хуудас, Санхүүгийн зохицуулах хороо (“**СЗХ**”)-ноос шаардлагатай гэж үзсэн тохиолдолд бусад олон нийтийн хэрэгслээр дамжуулан хүргэхийг ойлгоно.
- 1.5.4. **Нийтийн хүртээл болохоос өмнө** гэдгийг Компани нь энэ Журмын 1.5.3-т заасан хэлбэрээр энэ Журмын 2-р зүйлд заасан мэдээлэл болон Компанийн Дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчдийн үйл ажиллагааны журмын 4-р зүйлд заасан дотоод мэдээллийг нийтийн хүртээл болгохоос өмнө хугацааг хэлнэ.
- 1.5.5. **Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч** гэж Компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт

эзэмшиж байгаа болон тэдгээрийн саналын эрхийг хууль болон гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг ойлгоно.

- 1.5.6. **Тухай бүр мэдээлэх** гэж энэ Журамд заасан тухай бүр мэдээлэх мэдээллийг Компанийн болон МХБ-ийн цахим хуудас, СЗХ-ноос тогтоосон бусад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэхийг ойлгоно.
- 1.5.7. **Хугацаат тайлан** гэж Компаниас хувьцаа эзэмшигчдийн хуралд болон хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх зорилгоор өөрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг агуулсан баримт бичгийг ойлгоно.
- 1.5.8. **Хяналтын багц эзэмшигч** гэж Компанийн гаргасан энгийн хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг эзэмшигчийг ойлгоно.
- 1.5.9. **Эрх бүхий албан тушаалтан** гэж ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон ТУЗ-өөс эрх бүхий албан тушаалтнаар тооцсон бусад этгээдийг ойлгоно.

2. НИЙТЭД МЭДЭЭЛЭХ МЭДЭЭЛЭЛ

2.1. Хугацаат тайлагнал

- 2.1.1. Компанийн хугацаат тайлагнал нь хагас жилийн болон жилийн эцсийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан хамаарах бөгөөд Компанийн жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 04-р сарын 30-ны өдрийн дотор энэ Журмын 2.1.2-т заасан агуулгаар, хагас жилийн үйл ажиллагааны тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор энэ Журмын 2.1.3 дэх хэсэгт заасан агуулгаар Компанийн болон МХБ-ийн цахим хуудсаар дамжуулан нийтэд хүргэнэ.
- 2.1.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан нь дараах мэдээллийг агуулсан байна.
 - 2.1.2.1. Компанийн санхүүгийн талаарх мэдээлэл:
 - (i) Жилийн санхүүгийн тайлан тэнцэл, тодруулга;
 - (ii) Хөндлөнгийн аудиторын баталгаат захидал;
 - (iii) Санхүүгийн жилд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл; болон
 - (iv) Хөрөнгө оруулагч болон хувьцаа эзэмшигч хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай санхүүгийн нөхцөл байдал, төлбөрийн ба хөрвөх чадварыг тодорхойлоход шаардлагатай мэдээлэл.
 - 2.1.2.2. Компанийн Гүйцэтгэх удирдлагаас гаргах тайлангийн мэдээлэл:
 - (i) Тайлант жилд Компанийн орлогод нөлөөлсөн гадаад, дотоод орчны нөлөөллийг тусгасан дүгнэлт, мэдээлэл;
 - (ii) Компанийн богино, дунд, урт хугацааны төлбөрийн болон хөрвөх чадварын үзүүлэлтүүд, Компани өөрийн санхүүгийн нөөцөөр бизнесийн үйл ажиллагаанаас бий болсон өр төлбөрийг бүрэн хариуцах боломж, шаардлагатай тохиолдолд гадаад, дотоод санхүүжилтийн эх үүсвэрээс санхүүжилт татах боломжтой эсэх дүгнэлт, мэдээлэл;
 - (iii) Компанийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь,

бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэчлэл, төрөлжилт, дээрх өөрчлөлтөд Компанийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл; болон

(iv) Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаарх товч мэдээлэл.

2.1.2.3. Сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн талаарх мэдээлэл, эдгээр хэлцлийг хийснээр гарах үр дүн, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл.

2.1.2.4. ТУЗ-ийн хараат болон хараат бус гишүүд, Гүйцэтгэх удирдлагад олгосон цалин урамшуулал, шагнал, тэдгээрийн эзэмшдэг опцион болон хувьцааны тоо ширхэг, нөхөн олговор, урамшуулал, шагналын талаарх баримталдаг бодлого.

2.1.2.5. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл:

(i) ТУЗ-ийн дарга, хараат, хараат бус гишүүд, Гүйцэтгэх удирдлагын мэдээлэл, удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт;

(ii) ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүрэг, хариуцлага, гишүүдийн нэр, боловсрол, ажлын туршлага, ёс зүйн кодекс, эрсдэлийн удирдлагын хэрэгжилт;

(iii) ТУЗ болон түүний дэргэдэх хороодын ажлын тайланг хэлэлцсэн хувьцаа эзэмшигчдийн хурлын дүгнэлт;

(iv) Гүйцэтгэх удирдлагын ажлын тайланг хэлэлцсэн ТУЗ-ийн дүгнэлт;

(v) Дотоод аудитын ажлын тайланг хэлэлцсэн ТУЗ-ийн дүгнэлт, мэдээлэл; болон

(vi) Шаардлагатай тохиолдолд СЗХ-ноос баталсан үнэлгээний аргачлалын дагуу Компанийн засаглалыг үнэлсэн үнэлгээний тайлан.

2.1.2.6. Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл:

(vii) Компанийн гадаад худалдаа болон арилжаанд бий болсон зах зээлийн эрсдэлийг удирдах чиглэлээр гаргасан үүсмэл санхүүгийн болон бусад хэрэгслийн мэдээлэл; болон

(viii) зах зээлийн эрсдэлийг тооцдог арга аргачлал, эрсдэлийг удирдах стратегийн талаарх мэдээлэл.

2.1.2.7. Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл:

(i) Компанийн тайлант жил дэх эцсийн өмчлөгч болон нөлөө бүхий, хяналтын багц эзэмшигчийн нэрс, хувьцааны тоо ширхэг, төвлөрлийн мэдээлэл;

(ii) Компанийн охин, хараат компанийн мэдээлэл; болон

(iii) Тайлант хугацаанд Компанийн тухай хуульд заасны дагуу шаардах эрхээ хэрэгжүүлэн хувьцаа худалдсан хувьцаа эзэмшигчийн тоо, үнийн дүнгийн мэдээлэл.

2.1.2.8. Ногдол ашгийн мэдээлэл:

- (i) Ногдол ашгийн бодлого;
 - (ii) Тухайн жилд хуваарилсан ногдол ашгийн хэмжээ, тараах хэлбэр, ногдол ашиг хуваарилахгүй тохиолдолд энэ талаарх үндэслэл; болон
 - (iii) Өмнөх жилд ногдол ашиг хуваарилсан тохиолдолд түүний тараалтын тайлан, мэдээлэл.
- 2.1.2.9. Нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлан, мэдээлэл.
- 2.1.2.10. Бусад шаардлагатай мэдээлэл:
 - (i) Энэ Журмын 2.2-т заасан тухай бүр мэдээлэх шаардлагатай мэдээлэл; болон
 - (ii) Шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.
- 2.1.3. Компанийн хагас жилийн үйл ажиллагааны тайлан нь дараах мэдээллийг агуулсан байна.
 - 2.1.3.1. Хагас жилийн санхүүгийн тайлан, тодруулгын мэдээлэл;
 - 2.1.3.2. Тайлант хугацаанд Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан;
 - 2.1.3.3. Тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн талаарх мэдээлэл;
 - 2.1.3.4. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хорооноос хагас жилийн тайланг хэлэлцэж, тайланд тусгасан мэдээлэл үнэн зөв талаарх дүгнэлт;
 - 2.1.3.5. Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний мэдээлэл;
 - 2.1.3.6. Төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл; болон
 - 2.1.3.7. ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны Компанид эзэмшиж буй хувьцааны талаарх мэдээлэл, удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, дотоод аудитын ажлын тайланг хэлэлцсэн ТУЗ-ийн дүгнэлт, Гүйцэтгэх удирдлагын ажлын тайланг хэлэлцсэн ТУЗ-ийн дүгнэлт, эцсийн өмчлөгч болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл.
- 2.1.4. Энэхүү Журмын 2.1.1-**Error! Reference source not found.**-т заасан мэдээллийг бүрдүүлэх, мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг Компани, мэдээллийг нийтийн хүртээл болгох зөвшөөрлийг ТУЗ, мэдээллийг цаг хугацаанд нь нийтийн хүртээл болгох, Компанийн болон МХБ-ийн цахим хуудсанд байршуулах ажлыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцна.
- 2.2. **Тухай бүр мэдээлэх мэдээлэл**
 - 2.2.1. Компани нь дор дурдсан үйл явдал, өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухайн үйл явдал, өөрчлөлт болсноос хойш ажлын 1 өдөрт багтаан нийтийн хүртээл болгоно.
 - 2.2.1.1. Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц гэрээ, хэлцлийн талаар мэдээлэл;
 - 2.2.1.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан, хараат, охин компанид аливаа

- захиргааны болон эрүүгийн хэрэг үүсгэсэн эсэх талаар мэдээлэл, шүүхээс Дампуурлын тухай хуулийн дагуу эрх хүлээн авагч томилогдсон талаарх мэдээлэл;
- 2.2.1.3. Нийт активын 25 хувь ба түүнээс дээш хэмжээтэй тэнцэх үл хөдлөх хөрөнгийг бусдад шилжүүлэх, барьцаалсан эсхүл бусад компанийн хяналтын багц худалдан авсан гэрээ, хэлцлийн талаар мэдээлэл;
- 2.2.1.4. Балансын гадуурх бүртгэлийн талаар мэдээлэл;
- 2.2.1.5. Эрх бүхий этгээдээс санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу Компанийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэж үзэн дахин үнэлгээ хийхээр шийдвэрлэсэн тохиолдолд холбогдох шийдвэр, шийдвэрийг гаргах болсон нөхцөл, шаардлага, үнэ цэнэ нь буурсан хөрөнгө болон хөрөнгийн үнэ цэний бууралтын хэмжээ эсхүл хязгаарын тооцоолол;
- 2.2.1.6. Компани арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй байх хугацаанд биелүүлэх үүргийн хэрэгжилтийн талаар мэдээлэл;
- 2.2.1.7. Хөндлөнгийн аудиторын өөрчлөлтийн талаар мэдээлэл;
- 2.2.1.8. Өмнөх жилүүдийн санхүүгийн тайланд алдаа гарсан бол энэ талаар мэдээлэл;
- 2.2.1.9. Компанийн хяналтын багцыг бусад этгээдэд шилжүүлэхтэй холбоотой мэдээлэл;
- 2.2.1.10. Компанийн эрх бүхий албан тушаалтан, ТУЗ-ийн дарга, гишүүдийн өөрчлөлттэй холбоотой мэдээлэл;
- 2.2.1.11. Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийн талаар мэдээлэл;
- 2.2.1.12. Компанийн Гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн, гарсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд Компанийн хувьцааг бирж болон биржийн бус зах зээл дээр худалдах, худалдан авахыг хориглосон арга хэмжээний талаар мэдээлэл;
- 2.2.1.13. Компанийн ёс зүйн дүрэмд орсон өөрчлөлтийн талаар мэдээлэл;
- 2.2.1.14. Шинэ техник, технологи нэвтрүүлэх, шинэ бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл, патент, үйл ажиллагаа явуулах болон барааны тэмдэг эзэмших эрхийн талаар мэдээлэл;
- 2.2.1.15. Оноосон нэр, хаяг байршлын өөрчлөлт, салбар, төлөөлөгчийн газрын талаар мэдээлэл;
- 2.2.1.16. Үйл ажиллагааны чиглэл, түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлдээ зогссон эсэх талаар мэдээлэл; болон
- 2.2.1.17. Төлбөрийн чадваргүй болох, Компанийг татан буулгах шийдвэрийн талаар мэдээлэл.
- 2.2.2. Энэхүү Журмын 2.2.1-т заасан мэдээллийг бүрдүүлэх, мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг Компани, мэдээллийг нийтийн хүртээл болгох зөвшөөрлийг ТУЗ, мэдээллийг цаг хугацаандаа нийтийн хүртээл болгох, Компанийн болон МХБ-ийн цахим хуудсанд байршуулах ажлыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга тус тус хариуцна.

3. МЭДЭЭЛЛИЙГ НИЙТИЙН ХҮРТЭЭЛ БОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 3.1. Компани нь нийтийн хүртээл болгох мэдээллийг нэгэн зэрэг сонирхогч бүх этгээдэд Компанийн болон МХБ-ийн цахим хуудсаар тогтоосон хугацаанд мэдээлнэ. Компанийн цахим хуудсанд Хөрөнгө оруулагчид хэсэг байрших бөгөөд тус хэсгийн мэдээлэл 5 хүртэл жилийн хугацаанд хадгалагдах тохиргоотой байна.
- 3.2. Компанийн болон МХБ-ийн цахим хуудсаар дамжуулан нийтийн хүртээл болгосон мэдээллийг Компанийн албан ёсны мэдээлэл гэж үзэх бөгөөд Компани нь бусад олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр Компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргэж болно.
- 3.3. Компанийн болон МХБ-ийн цахим хуудсаар нийтэд мэдээлсэн мэдээллээс бусад олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар тархсан цуурхал, худал, ташаа мэдээлэл нь Компанийн үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөхөөр бол энэ талаар Компаниас нэмж мэдээлэл, тайлбарыг нийтэд хүргүүлж болно.
- 3.4. Компани нь дотоод мэдээллийг дор дурдсан хэлбэрээр нийтийн хүртээл болгоно. Үүнд:
 - 3.4.1. Компанийн болон МХБ-ийн цахим хуудсаар;
 - 3.4.2. СЗХ-оос тогтоосон журмын дагуу хэвлэн нийтлэх; болон
 - 3.4.3. Тухайн мэдээллийг сонирхогч этгээд саадгүй авах боломжийг хангасан бусад хэлбэрээр.
- 3.5. Энэхүү Журмын 2.1, 2.2 дох хэсэгт заасан баримт бичгийг 10 жилийн хугацаагаар хадгалах бөгөөд энэ хугацаа дууссаны дараа тэдгээрийг Компанийн Архивын ажлын зааварт заасан журмын дагуу архивт шилжүүлнэ.
- 3.6. Энэ Журмын 2.1, 2.2-г заасан мэдээллийг нийтэд хүргэхдээ СЗХ болон МХБ-ээс тогтоосон нэгдсэн маягт, загварын зааврыг баримтална.

4. КОМПАНИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ АВАХ

- 4.1. Компани нь жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр, тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо болон СЗХ болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын дүрэм, журмаар тогтоосон бусад мэдээллийг Компанийн үнэт цаас эзэмшигчийн хүсэлтээр танилцуулна.
- 4.2. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, Гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал, шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, үнэ төлбөртэй хуулбарлан авах бололцоог хувьцаа эзэмшигчид олгоно.
- 4.3. Хувьцаа эзэмшигчээс мэдээлэл авах хүсэлтээ цахим шуудангаар ирүүлсэн тохиолдолд түүний шаардсан энэхүү Журамд хориглоогүй мэдээллийг цахим шуудангийн хаягаар хүргүүлж болно.
- 4.4. Компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь Компанийн энгийн хувьцаа эзэмшигчийн эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, түүний эзэмшлийн хувьцааны тоо зэргийг агуулсан бүртгэлийг шаардан гаргуулах эрхтэй.
- 4.5. Компанийн Гүйцэтгэх удирдлага, эсхүл хувьцаа эзэмшигчдийн бүртгэл хөтлөх эрх бүхий байгууллага энэ Журмын 4.4 дэх хэсэгт заасан шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор шаардлага гаргасан өдрөөр тасалбар болгон бүртгэлийг гаргаж өгөх үүрэгтэй бөгөөд үүнтэй холбогдон гарах зардлыг шаардлага тавьсан этгээд хариуцна.

5. МЭДЭЭЛЛИЙГ НИЙТИЙН ХҮРТЭЭЛ БОЛГОХОД ТАВИГДАХ ХЯЗГААРЛАЛТ, ХОРИГЛОХ ЗҮЙЛ

- 5.1. Компани нь төөрөгдүүлсэн, хуурамч, бүрэн бус мэдээллийг нийтэд мэдээлэхийг хориглоно.

- 5.2. Дотоод мэдээлэл эзэмшигч нь энэхүү Журам болон Компанийн Дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчдийн үйл ажиллагааны журамд заасны дагуу мэдээллийг нийтийн хүртээл болгохоос өмнө уг мэдээллийг санамсаргүй болон санаатайгаар бусдад мэдээлэх, дамжуулах, ашиглах, бусдад олж авах нөхцөлийг бүрдүүлэхийг хориглоно.
- 5.3. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь МХБ-ээс түүнд олгосон мэдээлэл оруулах эрхийг ТУЗ-ийн зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах, ашиглуулах, хувийн зорилгоор ашиглахыг хориглоно.
- 5.4. Компаниас гаргаж буй аливаа мэдээлэл нь энэхүү Журмын 1.4-т заасан эрх зүйн баримт бичгүүдэд нийцсэн байна.

6. ХАРИУЦЛАГА

- 6.1. Энэ Журмыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэхээр бол холбогдох төрийн эрх бүхий байгууллагад хандаж зөрчлийн асуудлыг шийдвэрлүүлнэ.
- 6.2. Хэрэв хамаарах бол энэхүү Журмыг зөрчсөн этгээдэд дээр 6.1-т зааснаар хариуцлага хүлээлгэхээс гадна Компанийн дотоод журам болон (хэрэв бий бол) холбогдох гэрээнд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 6.3. Энэ Журмыг зөрчсөнөөс үүссэн хохирлыг хариуцлага ногдуулсан эсэхээс үл хамааран Компанийн буруутай ажилтан, албан тушаалтан хариуцаж арилгана.